



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/196

Хэрлэн сум

Т.Осгонд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” арвантавдугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын тэргүүний ажилтан Т.Осгоны нэрэмжит Зүүн бүсийн математикийн олимпиадад аймгаа төлөөлөн оролцох багш, сурагчдын унааны зардалд зориулан 619,000 (зургаан зуун арван есөн мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Чадварлаг багш, чанартай боловсрол” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ